



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 4/123

Батноров сум

Газарын байршил шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг Газрын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дэх хэсэг, 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуулийн этгээд Сэрвэнгийн хөгжил майнинг ХХК-ын Батноров сумын Бэрх 7-р багийн Дулаан гудамж 303 тоот хаягт байрлах ХААхуйн зориулалттай газар нь иргэдийн суурьшлын бүстэй хэт ойрхон тул газрын байршлыг зүүн тийш нь шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг Сэрвэнгийн хөгжил майнинг ХХК-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Т.Очирбат/-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч/Б.Өсөхбаяр/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ЖАВХЛАНБАЯР



230423342

Батноров сумын Засаг даргын
2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн
А/14 дугаар захирамжийн хавсралт



ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА

№	Газар эзэмшигчийн нэх (хоршоо)	Регистрийн н дугаар	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Хэмжээ м.кв(г а)	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	Бэрх чацаргана төгөл хоршоо		4092114	Бургасан ухаа		Мал аж ахуйн үйлдвэрлэл ийн зориулалт	15 жил
2	Ногоон хөгжил, ногоон хот хоршоо		4090935	Дулаан	0,5	Мал аж ахуйн үйлдвэрлэл ийн зориулалт	15 жил